

Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд

Санхүүгийн тогтвортой байдал гэх ойлголт нь өргөн хүрээг хамардаг бөгөөд ОУВС болон улс орнуудын хувьд тэдгээрийн эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын орчин, банк санхүүгийн зах зээл, үнэт цаасны зах зээл болон бусад салбаруудыг төлөөлүүлэн авч үздэг байна. Аливаа улс орны санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нь тухайн улс орны хөгжлийн гол үзүүлэлтүүдийн нэг байдаг. Улс орон болгон өөрийн онцлогоос хамааралтайгаар санхүүгийн тогтвортой байдлыг авч үздэг. Манай орны хувьд санхүүгийн тогтвортой байдлыг эдийн засгийн орчин, олон улсын эдийн засаг үнийн орчин, хөрш орнуудын эдийн засгийн байдал, санхүүгийн салбарыг төлөөлүүлэн авах(манай орны хувьд санхүүгийн зах зээлийн 95.3 хувийг банкны салбар эзэлдэг) боломжтой. Олон улсын валютын сангаас санхүүгийн системийн тогтвортой байдал, түүнийг хүчирхэгжүүлж хяналт тавих, үнэлгээ хийхэд туслах зорилгоор санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тооцдог болсон. Өнгөрсөн үеүүдэд гарч байсан олон улсын банк, санхүү, эдийн засгийн хямралууд нь санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-аас тооцоолох шаардлагыг бий болгосон бөгөөд гишүүн орнуудын мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн жагсаалт болон тооцоолох аргачлалыг боловсруулан гаргасан байдаг. Үүний үр дүнд санхүүгийн тогтвортой байдлын 40 үзүүлэлтийг ОУВС-ийн удирдах зөвлөлд танилцуулан батлуулсан байдаг ба хадгаламж татан төвлөрүүлэгчийн салбарт 25 үзүүлэлтийг(үүнээс 12 үзүүлэлт нь үндсэн), үлдэх 15 нь бусад санхүүгийн байгууллагуудтай холбоотой үзүүлэлтүүд байдаг байна.

Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд нь:


1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
2. Хөрөнгийн чанар
3. Ашигт ажиллагаа
4. Хөрвөх чадвар
5. Зах зээлийн эрсдэлийн мэдрэмж

гэсэн үндсэн 5 бүлгээс бүрдэх бөгөөд нийт 12 үндсэн үзүүлэлтүүдийг тооцоолдог. Мөн түүнчлэн мета-өгөгдлүүдийг болон нэмэлтээр үзүүлэлтүүдийг тооцон авдаг. ОУВС-аас

2007-2008 оны хооронд гарсан олон улсын санхүүгийн зах зээлийн хямралаас авсан сургамжид үндэслэн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн жагсаалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа.


I. Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт (FSI) улс орнуудтай харьцуулсан судалгаа

Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа(CAR)




Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (Tier 1)




Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Эрсдэлийн сангийн дараахи чанаргүй зээл



Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.



Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Монгол улсын банкны салбарын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт эрх хүлээн авагч томилогдсон банкуудын үзүүлэлтийг хассанаар 2010 оны эцсийн байдлаар 16.2 хувьд хүрсэн нь бусад ОУВС-ийн гишүүн орнуудтай¹ харьцуулахад өндөр байна.

ОУВС-ийн гишүүн орнуудын санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг² бүлгээр нь авч үзвэл G-20 орнуудаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт хамгийн багатай орон Австрали(11.6%) байгаа бол хамгийн их нь ОХУ(20.9%) байна. Ази тивийн орнуудаас хамгийн өндөр өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлттэй орон нь

¹ WHD – өмнөд ба хойд америк тивийн орнууд (Western hemisphere countries), ED – хөгжиж байгаа эдийн засагтай орнууд (emerging and developing economies), OECD-эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн орнууд(organization for economic cooperation and development), G20 их 20 орнууд (group of 20 countries), EUR-европын орнууд (European countries), APD – ази, далайн орнууд(asian and pacific countries)


² Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар нь авсан болно.

Малайз(17.8%), европын бүс нутгаас Швед(10.1%), Украин (22.4%) байгаа бол хөгжиж байгаа эдийн засагтай орнуудаас Унгар(11.2%), Армени (28.8%) орнууд хамгийн бага болон их үзүүлэлттэй байлаа.

Өмнөд ба хойд америкийн бүс нутагт эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн чанаргүй зээл нийт зээлийн харьцаа дунджаар хамгийн бага буюу 1.6 хувьтай байгаа бол европын бүс нутагт дунджаар уг харьцаа манай орноос 9.5 хувиар өндөр байна. Харин чанаргүй зээлийн харьцаагаараа хамгийн бага түвшинтэй бүс нутаг нь ази болон далайн орнууд байгаа бол хөгжиж байгаа орнуудын дундаж үзүүлэлт 5.3 хувьтай байна. Манай орны хувьд бусад бүс нутгуудаас харьцангуй дээр байгаа юм.


Улс орнуудын хувьд эрсдэлийн дараахи чанаргүй зээлийн харьцаа болон чанаргүй зээлийн харьцааны үзүүлэлтүүд өөр байгаа нь эрсдэлийн сангийн хувь хэмжээ болон хууль, эрх зүйн зохицуулалттай тодорхой хэмжээгээр холбоотой.

Активын өгөөжийн үзүүлэлт




Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт



Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Хүүгийн бус зардал нийт орлогын харьцаа



Тайлбар-1: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Тайлбар-2: Хүүгийн бус зардалд эрсдэлийн сан, үнэлгээний хасагдуулгын зардал болон бусад зардлыг оруулан тооцлоо.


Манай улсын банк санхүүгийн зах зээлийн ашигт ажиллагаа 2010 онд сайжирсан нь өөрийн хөрөнгийн өгөөж болон активын өгөөжийг өндөр гарахад голлон нөлөөллөө. Бусад бүс нутгуудтай харьцуулахад активын өгөөжийн хэмжээ 0.2-1.4 нэгжээр илүү байгаа нь ашигт ажиллагаа өндөр байгааг харуулсан үзүүлэлт юм. Европын бүс нутагт өнгөрсөн хэдэн жилд банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал суларсан нь ашигт ажиллагааг бууруулсан байж болзошгүй юм. Бусад бүс нутгуудтай харьцуулахад хамгийн бага нь

европын бүс нутаг байгаа ба активын өгөөжийн хэмжээ 0.4 хүрсэн бөгөөд тус бүс нутагт хамгийн өндөр ашигт ажиллагааны үзүүлэлттэй байгаа нь Турк улс (3.2) байгаа бол хамгийн муу үзүүлэлттэй улс нь Латви(-3.9) байна. Банк санхүүгийн зах зээлийн хямралтай холбоотойгоор улс орнуудын банк санхүүгийн салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд муу байсан.

Ази, далайн орнууд болон өмнөд ба хойд америкийн улсуудын өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшин бусад бүс нутгуудтай харьцуулахад өндөр байгаа нь харагдаж байна. Европын орнууд болон OECD-ийн бүс нутагт өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт багатай байна. OECD гишүүн орнуудын хүрээнд аваад үзвэл Турк улс(25.8) хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бол Голланд улс (-12.5%) хамгийн бага үзүүлэлттэй байна. Ази тивийн улс орнуудын үзүүлэлт³ бусад улсуудынхтай харьцуулахад өндөр байгаа бөгөөд хамгийн өндөр нь Индонези(26.8) хамгийн бага нь Малайз(8.2) улсууд байна.

Хүүгийн бус зардал нийт орлогын харьцааны хувьд манай орны үзүүлэлт бусад бүс нутгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад 4.1-21.2 нэгжээр өндөр байлаа. Энэ нь манай оронд гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал нийт орлогын 58.4 хувийг эзэлж байгаатай холбоотой юм.

Хөрвөх актив нийт активын харьцаа




Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Тайлбар: Хөрвөх чадвар бүхий активт нийт мөнгөн хөрөнгө, төв банкны үнэт цаас болон клирингийн тооцооны зөрүү, клирингийн саатлын дүнгүүдийг авч тооцсон болно⁴.

Хөрвөх актив богино хугацаат эх үүсвэрийн харьцаа

³ Олон улсын валютын санд санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ази тивээс мэдээлдэг нийт 8 орон (Австрали, Хонгконг, Энэтхэг, Индонези, Солонгос, Малайз, Филиппин, Сингапур) байгаа юм. Ийм учраас тухайн бүс нутгийн үзүүлэлтүүд өндөр гарах боломжтой.


⁴ Улс орнууд хөрвөх активынхаа хэмжээг тооцоолохдоо харилцан адилгүй байдаг нь харьцааны үзүүлэлт өөр байхад зарим байдлаар нөлөөлдөг.



Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Тайлбар: Богино хугацаат эх үүсвэрийн хэмжээг тооцоолохдоо нийт харилцахын үлдэгдэл, 1 жил хүртэлх хугацаатай хадгаламжууд, нийт хугацаагүй хадгаламжууд цэвэршүүлсэн, цэвэршүүлээгүй тооцсон алт, мөнгөний харилцах, 1 жил хүртэлх хугацаатай хадгаламжууд, хадгаламжийн сертификат, репо нөхцөлөөр худалдсан үнэт цаас, банк хоорондын захын харилцах, хадгаламж богино хугацаа эх үүсвэр болон бусад татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг оруулан тооцлоо.

Гадаад валютын нээлттэй цэвэр позици өөрийн хөрөнгийн харьцаа



Тайлбар: Монгол улсын тоон мэдээллийг 2010 оны 12 сарын 31-ны байдлаар авсан. Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар(2008-2009 оны эцсийн байдлаар, 2010 оны эхний 2 дугаар улирлын байдлаар) нь авсан болно.

Богино хугацаат эх үүсвэр, хугацаагүй болон хугацаатай хадгаламжийн хэмжээ ихээр нэмэгдсэн нь манай орны хувьд хөрвөх чадвар өндөртэй активыг өндөрөөр барих шаардлагыг гаргаж ирсэн. Тус нөлөөллөөс шалтгаалан манай орны хөрвөх актив болон нийт активын харьцаа бусад бүс нутгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байлаа.

Азийн бүс нутагт Сингапур улс нийт активынхаа 69.3 хувийг хөрвөх чадвар өндөртэй активд байршуулсан байхад Европт Румын улс нийт активынхаа 59.2 хувиар, G20-д Турк 56.1 хувиар, OECD-д Люксембург 59 хувиар, өмнөд хойд америкийн бүс нутагт Бразил 52.5 хувиар хөрвөх активыг барьж байна.

Хөрвөх актив богино хугацаат эх үүсвэрийн харьцаагаар OECD-ийн бүс нутаг хамгийн өндөр, хөгжиж буй эдийн засагтай орнуудын бүс нутагт хамгийн бага байна. Олон улсын санхүүгийн зах зээлийн хямралтай холбоотойгоор улс орнууд богино хугацаатай татсан эх үүсвэрийнхээ дийлэнх хэсгийг хөрвөх чадвар өндөртэй активт байршуулсан. Европын банк санхүүгийн хямралаас шалтгаалан тухайн бүс нутагт нийт богино хугацаанд татан төвлөрүүлсэн эх үүсвэрийнхээ 64.4 хувийг хөрвөх чадвар өндөртэй активт байршуулсан байгаа бөгөөд Голланд улсын хувьд уг харьцаа 202.1 байгаа нь 1 жилээс доошхи хугацаатай татан төвлөрүүлсэн эх үүсвэрээсээ 2 дахин ихээр хөрвөх активаа барьж байгаа нь хөрвөх чадварын эрсдэлийн түвшинг илтгэсэн үзүүлэлт юм.

Манай орны банкны салбар гадаад валютын богино нээлттэй позицтой байгаа бөгөөд өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь -2.5 байна. Өмнөд ба хойд америкийн бүс нутгийн орнуудад гадаад валютын хөрөнгө оруулалтыг ихээр хийдэг нь харагдаж байгаа бол OECD бүс нутгийн орнуудад гадаад валютаар эх үүсвэрийг илүүтэй татдаг нь харагдаж байна. Уг харьцаа нь Украйнд 27.4, Норвегид -90.7, Швейцар -23 байдаг бол Эл Салвадор улсад 100 байгаа нь нийт өөрийн хөрөнгөтэй тэнцүү хэмжээгээр гадаад валютын нээлттэй урт позицийг барьдаг байна.